

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2026/029/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089116 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170, Цахим хаяг: [dalaivan.et@gmail.com](mailto:dalaivan.et@gmail.com)

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 99921600, Цахим хаяг: [dalaivan.orkhon@gmail.com](mailto:dalaivan.orkhon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/119  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА  
Т.ЛХАГВАДОРЖ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 291,918.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 13,303.2 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлж 8,300.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 962.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 4,041.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

#### Бусад асуудлын хэсэг

Байгаль орчны газар нь Хөвсгөл аймгийн Засаг даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 98.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,004,951,475.13</u></b>	<b><u>1,599,366,970.83</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	583,436,257.90	365,316,549.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	409,528.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	583,026,729.90	365,316,549.60
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,421,515,217.23	1,234,050,421.23
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,421,515,217.23	1,234,050,421.23
35410	Бичиг хэргийн материал	12,843,675.00	4,667,722.00
35420	Аж ахуйн материал	47,046,530.23	48,972,030.23
35430	Сэлбэг хэрэгсэл	30,800.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,049,000.00
35450	Барилгын засварын материал	165,196,500.00	165,085,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,196,397,712.00	1,013,276,669.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,228,336,737.31</u></b>	<b><u>2,186,810,310.17</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,228,336,737.31	2,186,810,310.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	634,978,237.47	594,426,560.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,573,259.00	323,573,259.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-41,137,713.58	-48,687,068.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	353,458,495.00	354,058,495.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-170,421,661.80	-181,998,995.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,114,549.78	354,866,712.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-171,275,139.95	-227,449,553.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,263,808.54	43,483,943.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,744,078.39	-29,069,485.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,224,660.00	25,224,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,077,941.13	-19,575,407.13
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,593,358,499.84	1,592,383,750.00
39301	Програм хангамж	17,070,000.00	17,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,221,500.16	-7,196,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,582,510,000.00	1,582,510,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,233,288,212.44</u></b>	<b><u>3,786,177,281.00</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>247,265,626.65</u></b>	<b><u>495,676,359.56</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	247,265,626.65	495,676,359.56
<b>413</b>	<b>Өглөг</b>	247,265,626.65	495,676,359.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	181,354,609.65	166,317,894.56
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	59,141,117.00	326,868,265.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	6,769,900.00	2,490,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,769,900.00	2,490,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,986,022,585.79</u></b>	<b><u>3,290,500,921.44</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,986,022,585.79	3,290,500,921.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,939,814,650.02	1,939,814,650.02
51101	Өмч: - төрийн	1,734,050,150.02	1,734,050,150.02
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	205,764,500.00	205,764,500.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,998,294,145.17	1,302,772,480.82
51210	Өмнөх үеийн үр дүн	1,998,294,145.17	1,998,294,145.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-695,521,664.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,913,790.60	47,913,790.60

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,233,288,212.44</b>	<b>3,786,177,281.00</b>
---	--	-------------------------	-------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,828,473,195.00</b>	<b>2,900,230,412.42</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,550,460.00</b>	<b>403,886,307.40</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,550,460.00	403,886,307.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	750,000.00	2,061,772.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	2,061,772.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,823,922,735.00</b>	<b>2,496,344,105.02</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	867,770,535.00	387,574,260.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	736,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,543,400.00	75,380,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	614,491,135.00	312,194,060.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,956,152,200.00	2,108,769,845.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,956,152,200.00	2,108,769,845.02
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,125,830,871.58</b>	<b>3,595,752,076.77</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,125,830,871.58</b>	<b>3,595,752,076.77</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,726,858,420.19	3,462,215,430.44
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,810,557,109.65	1,757,468,925.88
210101	Үндсэн цалин	1,241,449,895.03	1,189,829,831.66
210102	Нэмэгдэл	479,074,777.10	516,026,738.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,707,702.19	51,612,355.53
210104	Урамшуулал	20,324,735.33	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	187,267,000.00	205,730,200.00
210201	Тэтгэврийн даатгал	127,341,500.00	139,896,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,981,400.00	16,458,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,490,700.00	8,229,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,490,700.00	8,229,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,962,700.00	32,916,800.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,487,599.01	34,079,045.02
210301	Гэрэл, цахилгаан	3,778,285.29	3,136,080.42
210302	Түлш, халаалт	19,071,020.72	29,930,502.60
210303	Цэвэр, бохир ус	1,638,293.00	1,012,462.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,990,266.36	48,842,053.00
210401	Бичиг хэрэг	28,004,317.00	13,979,733.00
210402	Тээвэр, шатахуун	19,688,550.00	17,925,489.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,304,728.00	3,947,880.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,992,671.36	12,988,950.00
2105	<b>Нормативт зардал</b>	6,700,000.00	298,666,737.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,700,000.00	298,666,737.40
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,258,700.00	12,622,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,945,900.00	1,330,800.00
210604	Урсгал засвар	11,312,800.00	11,291,800.00

Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,839,800.00	11,261,000.00
210702	Дотоод албан томилолт	3,839,800.00	11,261,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	490,791,697.60	1,007,446,144.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,746,197.60	1,000,146,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	588,800.00	336,842.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,000.00	00.00
210807	Газрын төлбөр	6,758,700.00	5,162,322.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	119,966,247.57	86,098,725.14
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,966,247.57	86,098,725.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	398,972,451.39	133,536,646.33
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	398,954,706.00	127,201,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	269,213,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	120,354,006.00	40,775,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	75,380,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,387,700.00	11,046,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	17,745.39	6,335,446.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,745.39	6,335,446.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>702,642,323.42</b>	<b>-695,521,664.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>702,642,323.42</b>	<b>-695,521,664.35</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,139,234,208.90</b>	<b>3,083,215,034.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>750,000.00</b>	<b>2,061,772.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	750,000.00	2,061,772.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	750,000.00	2,061,772.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	2,061,772.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,138,484,208.90</b>	<b>3,081,153,262.92</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,182,332,008.90	972,383,417.90
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	736,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,543,400.00	658,406,929.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	929,052,608.90	313,976,488.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,956,152,200.00	2,108,769,845.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,956,152,200.00	2,108,769,845.02
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,929,578,908.90</b>	<b>3,049,944,534.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,929,578,908.90</b>	<b>3,049,944,534.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,944,249,327.61</b>	<b>2,551,091,338.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,629,202,500.00	1,772,505,640.97
210101	Үндсэн цалин	1,060,095,285.38	1,204,866,546.75
210102	Нэмэгдэл	479,074,777.10	516,026,738.69

Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,707,702.19	51,612,355.53
210104	Урамшуулал	20,324,735.33	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>187,267,000.00</b>	<b>205,730,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	127,341,500.00	139,896,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,981,400.00	16,458,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,490,700.00	8,229,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,490,700.00	8,229,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,962,700.00	32,916,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,487,599.01</b>	<b>34,079,045.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,778,285.29	3,136,080.42
210302	Түлш, халаалт	19,071,020.72	29,930,502.60
210303	Цэвэр, бохир ус	1,638,293.00	1,012,462.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,724,710.00</b>	<b>37,528,200.00</b>
210401	Бичиг хэрэг	15,417,217.00	4,633,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,688,550.00	17,925,489.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,304,728.00	3,947,880.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,314,215.00	11,021,830.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,998,600.00</b>	<b>7,260,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,998,600.00	7,260,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,543,900.00</b>	<b>12,257,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	543,900.00	3,348,900.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,908,300.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>3,839,800.00</b>	<b>11,261,000.00</b>
210702	Дотоод албан томилот	3,839,800.00	11,261,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,039,870,218.60</b>	<b>470,470,053.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,029,824,718.60	463,170,889.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	588,800.00	336,842.00
210807	Газрын төлбөр	6,758,700.00	5,162,322.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,315,000.00</b>	<b>00.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,315,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>985,329,581.29</b>	<b>498,853,195.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>402,285,106.00</b>	<b>127,201,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	272,543,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	120,354,006.00	40,775,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	75,380,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,387,700.00	11,046,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>583,044,475.29</b>	<b>371,651,995.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	583,044,475.29	371,651,995.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>209,655,300.00</b>	<b>33,270,500.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>209,655,300.00</b>	<b>33,270,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>209,655,300.00</b>	<b>33,270,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>209,655,300.00</b>	<b>33,270,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	209,655,300.00	33,270,500.00

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-209,655,300.00</b>	<b>-33,270,500.00</b>
---	--	------------------------	-----------------------

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,939,814,650.02	47,913,790.60	1,998,294,145.17	3,986,022,585.79
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,939,814,650.02	47,913,790.60	1,998,294,145.17	3,986,022,585.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,939,814,650.02	47,913,790.60	1,998,294,145.17	3,986,022,585.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-695,521,664.35	-695,521,664.35
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,939,814,650.02	47,913,790.60	1,302,772,480.82	3,290,500,921.44

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,182,186,900.00	2,110,810,845.02	71,376,054.98	96.73
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,182,186,900.00	2,110,810,845.02	71,376,054.98	96.73
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,130,350,100.00	2,052,654,398.69	77,695,701.31	96.35
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,697,680,200.00	1,667,851,247.67	29,828,952.33	98.24
210101	Үндсэн цалин	1,094,712,700.00	1,102,085,126.78	-7,372,426.78	100.67
210102	Нэмэгдэл	547,330,000.00	514,153,765.36	33,176,234.64	93.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,637,500.00	51,612,355.53	4,025,144.47	92.77
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	205,730,200.00	205,730,200.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	139,896,600.00	139,896,600.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,458,400.00	16,458,400.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,229,200.00	8,229,200.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,229,200.00	8,229,200.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,916,800.00	32,916,800.00	0.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,138,700.00	34,079,045.02	-940,345.02	102.84
210301	Гэрэл, цахилгаан	2,725,100.00	3,136,080.42	-410,980.42	115.08
210302	Түлш, халаалт	29,630,900.00	29,930,502.60	-299,602.60	101.01
210303	Цэвэр, бохир ус	782,700.00	1,012,462.00	-229,762.00	129.36
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,177,900.00	32,528,200.00	-350,300.00	101.09
210401	Бичиг хэрэг	4,633,000.00	4,633,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,544,900.00	13,367,489.87	177,410.13	98.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,000.00	3,505,880.13	1,294,119.87	73.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,200,000.00	11,021,830.00	-1,821,830.00	119.80
2105	<b>Нормативт зардал</b>	7,260,000.00	7,260,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,260,000.00	7,260,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,715,300.00	35,697,800.00	-982,500.00	102.83

Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	24,366,500.00	25,309,500.00	-943,000.00	103.87
210602	Тавилга	1,480,000.00	1,480,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,868,800.00	8,908,300.00	-39,500.00	100.45
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,400,000.00</b>	<b>11,261,000.00</b>	<b>139,000.00</b>	<b>98.78</b>
210702	Дотоод албан томилолт	11,400,000.00	11,261,000.00	139,000.00	98.78
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>108,247,800.00</b>	<b>58,246,906.00</b>	<b>50,000,894.00</b>	<b>53.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,748,600.00	52,747,742.00	50,000,858.00	51.34
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,900.00	336,842.00	58.00	99.98
210807	Газрын төлбөр	5,162,300.00	5,162,322.00	-22.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51836800.00</b>	<b>51821000.00</b>	<b>15,800.00</b>	<b>99.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,836,800.00</b>	<b>51,821,000.00</b>	<b>15,800.00</b>	<b>99.97</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,790,800.00	40,775,000.00	15,800.00	99.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,202,000.00	11,046,000.00	3,156,000.00	77.78
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,182,186,900.00</b>	<b>2,110,810,845.02</b>	<b>71,376,054.98</b>	<b>96.73</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,181,186,900.00</b>	<b>2,108,769,845.02</b>	<b>72,417,054.98</b>	<b>96.68</b>
132001	Орон нутгийн төсвөөс	2,181,186,900.00	2,108,769,845.02	72,417,054.98	96.68
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>2,041,000.00</b>	<b>-1,041,000.00</b>	<b>204.10</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,041,000.00	-1,041,000.00	204.10
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>73.00</b>	<b>73.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	69.00	69.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100.00

**2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>972,404,189.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>972,404,189.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,707,440.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>104,654,393.30</b>
210101	Үндсэн цалин	102,781,419.97
210102	Нэмэгдэл	1,872,973.33
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	4,558,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	442,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>422,053,047.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	420,253,047.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,380,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>75,380,200.00</b>

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	75,380,200.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>365,316,549.60</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	365,316,549.60
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>972383417.90</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>972,383,417.90</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	658,406,929.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	313,976,488.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 192,008.1 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 190,208.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,800.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Байгаль орчны мэргэжилтэн Бат-баясах нь байгууллагад төвлөрүүлэх ойжуулалтын зардал 7 980.0 мянган төгрөгийг өөрийн дансанд авч ашигласан мөнгийг илрүүлэн арга хэмжээ авсан боловч тухайн мөнгийг бүртгэлд тусгаж тайлагнаагүй, авлагаар бүртгэж тайланд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 5 дугаар зүйлийн 5.1.4.ил тод байдлыг хангасан байх, 5 дугаар зүйлийн 5.1.5.хариуцлагатай байх. 6 дугаар зүйлийн 6.3.2.санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" зарчмуудыг зөрчсөн байна.
- Шатахууны урамшууллын 120.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу тайлагнаж, 200.0 мянган төгрөгийн усны дүгнэлтийн орлогыг авлага үүсгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14 дүгээр зүйлийн 14.4.5 "бүх орлого", Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан " Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 2.28.Ажил, үйлчилгээний орлогыг дараах байдлаар бүртгэнэ:(а) ажил, үйлчилгээг үзүүлээд орлогыг нэхэмжилсэн үед: Дт Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага Кт Төсвийн байгууллагын өөрийн орлого" гэсэн заалтыг зөрчсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

#### 3.2 Албан шаардлага

- Б.Минжүүр-жаргал 2025 оны бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд Байгууллагын даргын 2025 оны 8 сарын 26-ны Б/71 тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны албан тушаалыг хавсран гүйцэтгэснээр өөрийн цалингийн 25%-иар тооцон 962.2 мянган төгрөгийн цалинг бодож авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.Төсвийн шууд захирагч нь 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, 14 дугаар зүйлийн 14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шилэн дансанд 37 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4 дугаар зүйлийн 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Тайлагналын данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тайлангийн хугацаанд тус байгууллагын нярав солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.2 ".эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед тооллогыг үнэн бодитой хийх.

#### **2. Цалингийн данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

2024 оны 12 сард ажилд орсон Бичиг хэргийн ажилтан П.Нандинцэцэгт 2025 оны 02-р сарын 14-ний өдөр Б/14 тоот тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан үр бүтээлтэй ажиллаагүй, ажлын үр дүн болон ажлын бүтээмжийг харгалзалгүй 2025 оны 8 сард 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1.3. гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах; зэрэг хуулийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

#### **3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тус байгууллагын эзэмшлийн 6712017075 нэгж талбарын дугаар бүхий 10206м.кв, 6712016264 нэгж талбарын дугаар бүхий 10005 м.кв талбай бүхий газрын гэрчилгээтэй ба улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэлтэй боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3. холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх, Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлангийн хугацаанд тус байгууллагын нярав солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байна.	1	-					1	-		
Албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томиллоор ажилласан хугацаанд давхардуулан 4.928.0 мянган төгрөг илүү тооцож олгосон байна	1	4,928.0							1	4,928.0
Тус байгууллагын эзэмшлийн 6712017075 нэгж талбарын дугаар бүхий 10206м.кв, 6712016264 нэгж талбарын дугаар бүхий 10005 м.кв талбай бүхий газрын гэрчилгээтэй ба улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэлтэй боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй байна	1	-					1	-		
Цалингийн тооцооллыг шалгахад нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтийн цалинтай таарахгүй 4 216.2 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан.	1	4,216.2							1	4,216.2
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>9,144.2</b>					<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>9,144.2</b>

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагад төвлөрүүлэх ойжуулалтын зардал 7 980.0 мянган төгрөгийг өөрийн дансанд авч ашигласан мөнгийг илрүүлэн арга хэмжээ авсан боловч тухайн мөнгийг бүртгэлд тусгаж тайлагнаагүй, авлагаар бүртгэж тайланд тусгаагүй байна.	1	7,980.0	1	7,980.0	1	7,980.0				
Шатахууны урамшууллын 120.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу тайлагнаж , 200.0 мянган төгрөгийн усны дүгнэлтийн орлогыг авлага үүсгэж тайлагнаагүй байна.	1	320.0	1	320.0	1	320.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,300.0</b>	<b>2</b>	<b>8,300.0</b>	<b>2</b>	<b>8,300.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлангийн хугацаанд тус байгууллагын нярав солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байна	1	-					1	-				
2024 оны 12 сард ажилд орсон Бичиг хэргийн ажилтан П.Нандинцэцэгт 2025 оны 02-р сарын 14-ний өдөр Б/14 тоот тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан үр бүтээлтэй ажиллаагүй, ажлын үр дүн болон ажлын бүтээмжийг харгалзалгүй 2025 оны 8 сард 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон байна.	1	4,041.0					1	4,041.0				
Тус байгууллагын эзэмшлийн 6712017075 нэгж талбарын дугаар бүхий 10206м.кв, 6712016264 нэгж талбарын	1	-					1	-				

**Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

дугаар бүхий 10005 м.кв талбай бүхий газрын гэрчилгээтэй ба улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэлтэй боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.													
Б.Минжүүр-жаргал 2025 оны бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд Байгууллагын даргын 2025 оны 8 сарын 26-ны Б/71 тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны албан тушаалыг хавсран гүйцэтгэснээр өөрийн цалингийн 25%-иар тооцон 962.2 мянган төгрөгийн цалинг бодож авсан байна.	1	962.0			1	962.0							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,003.2</b>			<b>1</b>	<b>962.0</b>	<b>3</b>	<b>4,041.0</b>					

**Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шилэн дансанд 37 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна	1	-			1	-							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>							